

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2024/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар ав

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 380

танай _____-ны № _____-т

СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сэргэлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарч байна.

Аудитын гол асуудал

Сэргэлэн сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/02 дугаар тогтоолоор 94 хувиар үнэлсэн нь бодитой биш байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

011021215

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	707,796.10	706,576.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	347,029.00	293,694.50
33	АВЛАГА	146,948.90	168,784.30
35	БАРАА МАТЕРИАЛ	166,090.30	168,790.60
36	НӨӨЦИЙН БАРАА	47,728.00	75,307.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,549,733.60	2,159,213.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,549,733.60	2,159,213.40
39200	Биет хөрөнгө	1,499,132.10	2,050,092.50
39300	Биет бус хөрөнгө	50,601.40	109,120.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,257,529.70	2,865,789.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	27,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	27,000.00	0
41300	Өглөг	27,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,230,529.70	2,865,789.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,230,529.70	2,865,789.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	614,160.10	614,160.10
51200	Хуримтлагдсан үр дүн	1,438,269.00	2,073,529.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,100.50	178,100.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,257,529.70	2,865,789.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,206,755.80	2,342,410.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	267,818.40	407,634.80
110	Орлогын албан татвар	122,742.90	159,381.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	128,686.60	165,308.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,943.70	-5,927.50
113	Хөрөнгийн албан татвар	95,496.50	232,267.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	49,579.00	15,985.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	441,506.50	922,162.10
120	Нийтлэг татварын бус орлого	345,080.50	825,736.10
122	Тусламжийн орлого	96,426.00	96,426.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,497,430.90	1,012,613.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,599,793.10	1,158,012.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,599,793.10	1,158,012.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,561.30	1,034,785.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,320.60	492,740.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,543.20	59,965.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,037.00	14,952.10
2104	Хангамж, бараа материалын зардал	37,562.50	103,096.40
2105	Нормативт зардал	0	210.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,882.80	7,977.10
2107	Томилот, зочны зардал	5,524.00	9,261.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,329.60	121,659.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,361.60	224,922.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	757,231.80	123,227.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	606,962.80	1,184,397.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,769,579.20	545,137.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,162,616.40	639,260.10

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,394,458.60	4,394,458.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,312.50	-1,312.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,393,146.10	4,393,146.10
9	Тайлант үеийн үр дүн	-2,162,616.40	-2,162,616.40
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,230,529.70	2,230,529.70
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,230,529.70	2,230,529.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,000.00	-4,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,226,529.70	2,226,529.70
19	Тайлант үеийн үр дүн	639,260.10	639,260.10
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,865,789.80	2,865,789.80

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,945,406.90	1,581,538.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	267,818.40	407,634.80
110	Орлогын албан татвар	122,742.90	159,381.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	128,686.60	165,308.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,943.70	-5,927.50
113	Хөрөнгийн албан татвар	95,496.50	232,267.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	49,579.00	15,985.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	543.3	976.3
1181	Газрын төлбөр	49,035.60	14,887.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	122.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,157.60	161,290.10
120	Нийтлэг татварын бус орлого	83,731.60	64,864.10
122	Тусламжийн орлого	96,426.00	96,426.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,497,430.90	1,012,613.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,415,368.10	942,240.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,415,368.10	942,240.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	658,136.40	819,013.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,320.60	492,456.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,543.20	60,250.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,192.90	15,266.90
2104	Хангамж, бараа материалын зардал	32,221.80	40,764.80
2105	Нормативт зардал	1,440.00	200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,237.80	9,178.90
2107	Томилот, зочны зардал	5,524.00	9,261.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,329.60	122,139.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,326.40	69,495.50

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	757,231.80	123,227.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	530,038.80	639,297.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	587,776.70	636,631.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	587,776.70	636,631.90
2200	Дотоод эх үүсвэрээр	587,776.70	636,631.90
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-587,776.70	-636,631.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-56,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	56,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-57,737.90	-53,334.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	404,767.00	347,029.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	347,029.00	293,694.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,787,089.90	1,438,710.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	775,123.60	748,498.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,181.70	747,771.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,532.20	491,848.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,464.00	60,250.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,782.40	102,349.82
2104	Хангамж, бараа материалын зардал	37,165.90	36,210.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,713.40	19,581.91
2107	Томилолт, зочны зардал	8,912.00	8,596.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,693.90	3,339.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,917.90	25,594.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	941.90	727.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	941.90	727.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	795,587.90	634,211.90
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	216,378.40	56,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,787,089.90	1,467,796.17
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,311,438.30	1,228,686.92
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	379,225.60	142,683.25
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	96,426.00	96,426.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	124,129.29
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	153,214.66

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,542.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,542.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,042.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,554.22
2105	Нормативт зардал	200.00
2107	Томилолт, зочны зардал	664.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,900.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172,542.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,542.51
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,164.99
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,973.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,404.20

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 288.5 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 96.0 сая төгрөгийн авлагатай бөгөөд 80.4 сая төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэртэй хэдий ч тайлант онд огт төлөлт хийгдээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, журам”-ын 4.7 -д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 146.3 сая төгрөгийн 5 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Малын тоо толгойн албан татварын орлогын гүйцэтгэл 78.8 хувь буюу 61.7 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй
тайлан

хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”; гэсэн заалттай нийцэхгүй байна.

4. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт

Сэргэлэн сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/02 дугаар тогтоолоор 94 хувиар үнэлсэн байна.

Үнэлгээнээс түүвэрлэн үзэхэд булгийн эх хашаалах 47.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад тус ажлыг 100 хувь гэж үнэлсэн байгаа нь үнэлгээг бодитой хийгээгүй байна.

Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн зөвлөмж

Сумын хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлж, дүгнэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлага төлөгдөөгүй	1	80.40			1	80.40							
ОНХС-ийн төлөвлөсөн 5 ажил хийгдээгүй	1	146.30			1	146.3							
Малын тоо толгойн албан татвар бүрэн төвлөрөөгүй	1	61.70			1	61.70							
Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан	1								1	1			
ИТХ-д хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлэх зөвлөмж	1	-					1	-					
Дүн	5	288.4			3	288.4	1	-	1	1			



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/94 ДДА-2024/07/НА-СТА-ТЗ Чойбалсан хот
А/Н 03/11

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 61.7 сая төгрөгөөр тасарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх"; 41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн орлогыг батлагдсан нэр төрлөөр биелүүлэн ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргэлэн сумын Засаг дарга Б.Гантулга, санхүү албаны дарга Б.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

 И.СЭМЖИДМАА

АУДИТОР



Б.ОЮУНХЭРЛЭН



011041276



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/93 ДСА-2024/АН НА-С17А-ТТЗ Чойбалсан хот
А1170311

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, 30 ажлаас 146.3 сая төгрөгийн 5 ажил огт хийгдээгүй, 1 ажил нь дутуу хийгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргэлэн сумын Засаг дарга Б.Гантулга, санхүү албаны дарга Б.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

 И.СЭМЖИДМАА

Б.ОЮУНХЭРЛЭН



011041281



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 03/95 ДОА- 2024/07/НА-СМ-ТТЗ
А170311

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын 96.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага бөгөөд үүнээс 80.4 сая төгрөг нь шүүхийн шийдвэртэй боловч тайлант онд ямар ч төлөлт хийгдээгүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5 дахь "зээл зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 3.4.11 дэх "сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргэлэн сумын Засаг дарга Б.Гантулга, санхүү албаны дарга Б.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

 И.СЭМЖИДМАА
 Б.ОЮУНХЭРЛЭН



011041298



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 96 ДОН - 2024 / 07 / НА-ТА-ТТЗ Чойбалсан хот
А1170311

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэргэлэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэргэлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрч, албан шаардлага өгсөн 3 зөрчлийг давтан гаргасан. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Сэргэлэн сумын Засаг дарга Б.Гантулгад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011041290